

Эрдэс, уул уурхай, ашигт малтмал Сурах бичигт эрдсийн баялгийн төрөл зүйл, тэдгээрийн үйлдвэрлэл, хэрэглээ олборлох ба анхан шатны боловсруулах үйлдвэрлэлийн технологийн үндсийг товч хэлбэрээр тусгав.

Эл номд дэлхийн чулуулаг бүрхүүл, химийн найрлага, физик шинж, чулуулгийн ангилал, уул технологийн гэх өрөмдөгдөх, бутлагдах, элээх, тэслэгдэх шинж ба физик техникийн шинж чанар болох структур, текстур, нягт, нүх сүвшил, ан цавшил, чулуулгийн ба хийн динамик, термодинамик, цахилгаан соронзон, цацраг идэвхт шинж чанар зэргийн талаар гол үндсэн ойлголтыг өгөв.